

ДУНДГОВЬ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНД

Зөвлөмжийн хэрэгжилт  
хүргүүлэх тухай

Танай албанаас 2023 оны 10 сарын 09 ны өдөр хийсэн санхүүгийн хяналт шалгалт хийсэн зөвлөмжийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Зөвлөмжийн дагуу дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.


1. Орон нутгийн хөгжлийн сангаар ижил төстэй ажлыг хувааж батласан зөрчлийн тухайд 2023 оны төсөв батлахад 2022 оны 12 сард Соёлын төвийн дотоод их засварын ажил батлагдаж, 2023 онд хийсэн төсвийн тодотголын үеэр сумын 100 жилтэй холбоотой ариун цэврийн байгууламж хийх ажил Хурлаар хэлцэгдэж батлагдсан тул нэг байгууллагад цаг хугацааны хувьд ижил 2 ажил салгаж баталсан мэт болсон байна. 2024 оны төсөв төвийн тодотголд энэ асуудлыг анхаарч ажиллана.

2. Тусгай сангууд, Соёл хариуцсан нягтлан бодогч чөлөөтэй байгаа хугацаанд аймгийн санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй “Зоосон нүдэн” ХХКомпаниас ажлын туршлагатай гэрээт нягтлан ажиллуулж сангууд болон бусад чиглэлд танай өгсөн зөвлөмжийг албан шаардлагыг хэрэгжүүлж байна.

3. Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Хоршоо хөгжлийн сангийн зээлийн материал санхүүгийн баримтыг “Зоосон нүдэн” ХХКомпаниас ажлын туршлагатай гэрээт нягтлан 2013 оноос хойш бүх гэрээ, материалыг цэгцлэн тооцоолол хийж танай өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

4. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн гүйлгээг хянаж батлаж, ЗДТГ-ын бэлэн мөнгөний гүйлгээг гаргахгүй байгаа.

5. Эрүүл мэндийн төвийн төсвийн зарцуулалтанд дотоод хяналтын нэгжээс хяналт тавьж зөвлөгөө шаардлага өгч Төрийн сангийн зардлын гүйлгээний хяналтыг сайжруулан ажиллаж байна. Зөрчилтэй гүйлгээ хийгдээгүй баримтын бүрдлийг ханган ажиллаж байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Г.ДОЛГОРМАА